

БҮРТГЭЛИЙН БАЙГУУЛЛАГА ҮҮСЭН БАЙГУУЛАГДСАНЫ 80 ЖИЛИЙН ОЙН АРГА ХЭМЖЭЭ

**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 10 сарын 10-ны өдөр


Дугаар 1/15

Холбоотой үнэмлэх

“Улсын бүртгэл-80” аяны хүрээнд ажил зохион байгуулах тухай

Улсын бүртгэлийн Ерөнхий газрын Тамгын газрын даргын баталсан “Улсын бүртгэл-80” аяны удирдамжийг үндэслэл болгон ТУШААХ нь:

1. Монгол Улсад бүртгэлийн байгууллага үүсэж хөгжсөний 80-н жилийн ойг тохиолдуулан “Улсын бүртгэл-80” аяны хүрээнд зохион явуулах ажлын төлөвлөгөөг нэгдүгээр хавсралтаар, аяны удирдамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. “Улсын бүртгэл-80” аяны хүрээнд зохион явуулах ажлын төлөвлөгөөнд тусгагдсан үйл ажиллагаа бүрийг чанартай, үр дүнтэй зохион явуулахыг Иргэний бүртгэлийн тасгийн дарга бөгөөд Улсын ахлах бүртгэгч Я.Арвижих, Эд хөрөнгийн тасгийн дарга бөгөөд Улсын ахлах бүртгэгч Б.Энхзаяа, Хяналтын улсын байцаагч Д.Оюунчимэг нарт болон ажлын хэсэгт үүрэг болгосугай.
3. Төлөвлөгөөний дагуу зохион явуулсан ажлыг тухай бүр тайлагнаж ажиллахыг тухайн ажилд томилогдсон албан хаагч тус бүрт даалгасугай.
4. Энэ тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж үүрэг чиглэл өгч ажиллахыг Улсын ахлах бүртгэгч Я.Арвижих, Улсын ахлах бүртгэгч Б.Энхзаяа нарт үүрэг болгосугай.

ДАРГА  Г.ЧҮЛТЭМЖАМЦ

821710708-6 3245881

“УЛСЫН БҮРТГЭЛ-80” АЯНЫ ХҮРЭЭНД ЗОХИОН ЯВУУЛАХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

2020 оны 10 дугаар сарын 05-ны өдөр

Алтай хот

№	Аяны хүрээнд хийгдэх ажлууд	Хүрэх үр дүн	Явагдах		Хариуцах албан тушаалтан, тасга нэгж	Хамтран ажиллах газар, хэлтэс, албан тушаалтан	Тайлбар
			Газар	Хугацаа			
1.	“Улсын бүртгэл-80” сэдэвт үзэсгэлэн гаргах	Иргэд улсын бүртгэлийн байгууллагын талаар зохи мэдлэгтэй болсон байна.	Хэлтсийн үйлчилгээний заал	2020.10.28-наас	Иргэний бүртгэлийн тасга, Я.Арвижих /Улсын ахлах бүртгэгч бөгөөд иргэний бүртгэлийн тасгийн дарга/ Эд хөрөнгийн бүртгэлийн тасга Б.Энхзаяа /Улсын ахлах бүртгэгч бөгөөд Эд хөрөнгийн бүртгэлийн тасгийн дарга/	Хэлтсийн албан хаагчид	
2.	“Улсын бүртгэл-80” сэдэвт таны амьдралд хууль сурталчлах аян	Иргэд улсын бүртгэлийн хууль тогтоомжийн талаар зохи мэдлэгтэй болсон байна.	Хэлтсийн хурлын танхимд	2020.11 сарын 10-ны дотор	Эд хөрөнгийн бүртгэлийн тасга Б.Энхзаяа /Улсын ахлах бүртгэгч бөгөөд Эд хөрөнгийн бүртгэлийн тасгийн дарга/	Албан байгууллагын дарга, удирдлагууд	
3.	“Хариуцлагатай зааврал” аяны хүрээнд, хуулийн этгээдийн эцсийн	Аж ахуйн нэгж удирдлагууд хуулийн этгээдийн эцсийн өмчлөгч	Хэлтсийн үйлчилгээний заал	2020.09.23-ны өдөрөөс 12.20-ны өдрийн дотор	Хэлтсийн дарга Г.Чүлтэмжамц Хуулийн этгээдийн улсын бүртгэл 3 Цэндсүрэн	Аж ахуй нэгж байгууллагуудын удирдлагууд	

**УЛСЫН БҮРТГЭЛ-80 АЯНЫ ХҮРЭЭНД ЯВАГДАХ
“МИНИЙ ААВ, ЭЭЖИЙН АЖИЛ” ГАР ЗҮРГИЙН УРАЛДААНЫ УДИРДАМЖ**

2020.10.12

Нэг. Зорилго

Өсвөр үе хүүхэд багачуудад Улсын бүртгэлийн байгууллагын ажлыг сурталчлан таниулах, тэдний чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, зураг зурах авъяасыг хөгжүүлэх, дэмжих, дүн шинжилгээ хийх үр чадварыг хөгжүүлэхэд оршино.

Хоёр. Хамрах хүрээ

Гар зургийн уралдаанд: Хэлтсийн албан хаагчдын 7-12 дугаар ангийн Ерөнхий Боловсролын Сургуулийн сурагчид оролцоно.

Гурав. Тавигдах шаардлага

- Гар зургийн уралдаанд оролцогчид АЗ хэмжээтэй цаасан дээр гуаш, усан будаг, өнгийн хараандаа зэргийг ашиглан улсын бүртгэлийн байгууллагын онцлогийг харуулан өөрийн гараар зурсан байх.
- Бүтээлийн ар талд өөрийн овог, нэрийг бүтнээр бичих ба сум, сургууль, анги бүлэг, холбоо барих утасны дугаарыг үнэн зөв гаргацтай бичнэ.

Дөрөв. Материал хүлээн авах хугацаа

- Материалыг 2020.11.10-ны өдрийг хүртэл хүлээн авна.
- Гар зургийн уралдааны бүтээлийг хэлтсийн 202 тоот өрөөнд Мэдээлэл технологийн ажилтан Э.Баатарсүрэнд ирүүлнэ үү. Ирсэн бүтээлийг оролцогчдод буцаан олгохгүй.

Тав. Шагнал урамшуулал

- Эхний гурван байр эзлүүлэн өргөмжлөл, дурсгалын зүйлээр шагнаж урамшуулна.

Зургаа. Зохион байгуулагч

- “Улсын бүртгэлийн хэлтэс”
Холбоо барих утас: 94000801, 99231562

—ооо—

**“УЛСЫН БҮРТГЭЛ-80 АЯНЫ ХҮРЭЭНД ЯВАГДАХ
“МИНИЙ ААВ, ЭЭЖИЙН АЖИЛ” ГАР ЗҮРГИЙН УРАЛДААНЫ УДИРДАМЖ**

2020.10.12

“УЛСЫН БҮРТГЭЛ-80 АЯНЫ ХҮРЭЭНД ЯВАГДАХ
“МИНИЙ ААВ, ЭЭЖИЙН АЖИЛ” ГАР ЗҮРГИЙН УРАЛДААНЫ УДИРДАМЖ

Монгол улсад бүртгэлийн байгууллага үүсч хөгжсөний 80 жилийн ойг тохиолдуулан улсын бүртгэлийн хэлтсийн ажилтан, албан хаагчдын дунд “Улсын бүртгэл-80-Миний мэргэжил” сэдвээр эссэ бичлэгийн уралдаан зарлаж байна.

Зохион байгуулагч: “Улсын бүртгэлийн хэлтэс”

Зорилго: Улсын бүртгэлийн үйлчилгээг иргэн, хуулийн этгээдэд чирэгдэлгүй хүргэхэд чиглэсэн улсын бүртгэгчдийн бие даасан бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, мэргэжлээрээ бахархах, санал бодлоо чөлөөтэй цэгцтэй илэрхийлэх, асуудлыг шийдвэрлэх санал санаачлагыг хөгжүүлэн дэмжих, тэдгээрийг урамшуулах.

Тавигдах шаардлага:

Өгөгдсөн тодорхой сэдвийн хүрээнд сэдвийн мөн чанарыг нээн харуулах, тунгавдаж буй асуудлыг тодорхойлох, өөрийн санал болгож, тэдгээрийн үндэслэл болсон судалгаа, нотолгоог илэрхийлсэн байхаас гадна хэлбэрийн хувьд дараахь шаардлагыг хангасан байна.

- Үндсэн асуудлын хүрээнд бичигдсэн байх.
- Бодит баримт, тодорхой судалгаа жишээн дээр бичигдсэн байх.
- Шинэлэг санаа дүгнэлттэй байх.
- Монгол хэлээр 500-н үгэнд багтаан үг үсэг, дүрмийн болон утга найрууллын алдаагүй /Arial фон дээр үсгийн хэмжээ 11 байна/
- Албан тушаал, эцгийн болон өөрийн нэрээ бичсэн байна.

Хүлээн авах хугацаа:


Эссэний эхийг файл хэлбэрээр be462649@gmail.com гэсэн цахим хаягаар, цаасан эхийг 1% хэвлэж улсын бүртгэлийн хэлтсийн 202 тоот өрөөнд Архивч С.Баянаад 2020.11.10-ны өдрийн 17.00 цагаас өмнө ирүүлнэ үү.

Холбоо барих албан тушаалтан

Улсын бүртгэгч С.Чинзориг	99953511
Архивч С.Баянаа	88828466
Нарийн бичиг М.Бат-Эрдэнэ	94720303

ОЙН АРГА ХЭМЖЭЭНИЙ ХҮРЭЭНД ХИЙГДЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ, УДИРДАМЖИЙГ БАТЛАН ҮЙЛ АЖИЛЛАГААНДАА ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАЖ БАЙНА.

БҮРТГЭЛИЙН БАЙГУУЛЛАГА ҮҮСЭН БАЙГУУЛАГДСАНЫ 80 ЖИЛИЙН ОЙН АРГА ХЭМЖЭЭ



Сайн үйлсийн аяны хүрээнд /Хандив өгсөн болон бичиг баримтгүй иргэдийг бичиг баримтжуулах ажлын хүрээнд/

БҮРТГЭЛИЙН БАЙГУУЛЛАГА ҮҮСЭН БАЙГУУЛАГДСАНЫ 80 ЖИЛИЙН ОЙН АРГА ХЭМЖЭЭ



Сумдад нээлттэй хаалга өдөрлөг зохион байгуулж 3 төрлийн бүртгэлийг газар дээр нь хийж ажиллалаа.



Төрийн байгууллагуудын нээлттэй хаалганы өдөр” арга хэмжээг зохион байгуулж азтай үйлчлүүлэгч шалгаруулан гарын бэлэг гардуулан ажиллалаа.